



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/08/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан Уул аймаг, Дархан сум 2024 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 149
танай _____-ны № _____-т

ОРХОН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ХИШИГБУЯН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын “Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дархан-Уул аймгийн Орхон сумын “Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 323,022.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлаас давсан нь дангаараа болон эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Орхон сумын “Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь тайлант онд 477,038.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 625,870.4 мянган төгрөгийн зардал гарган, 148,831.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2023 оны 9 сарын 07 өдрийн Орхон сумын Засаг даргын 01-А/107 дугаар захирамжаар "Орхон дэлгэр" ХХК-иас уурын зуух, барилга, инженерийн шугам сүлжээг хүлээн авч, тус сумын аж ахуйн нэгж, айл өрхүүдийг дулаан эрчим хүчээр хангах ажлыг эхлүүлэн бүтэц орон тоо болон үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батласан байна.

Орхон сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолоор 2023 онд айл өрхийн энгийн хог хягдлыг цуглууж, тээвэрлэх үйлчилгээний сарын хураамжийг 8,000 төгрөг, аж ахуйн нэгж байгууллагын 1м.куб хог хаягдлын сарын хураамжийг 15,000 төгрөгөөр шинэчлэн тогтоож үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг төлөвлөж, 85.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	153,041.55	1,533,059.67
1.1.2	Дансны авлага	4,320,988.00	14,109,739.20
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	13,029,435.00	14,099,635.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,503,464.55	29,742,433.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,171,190,543.00	2,329,170,881.26
1.2.2	Биет бус хөрөнгө	63,617,249.89	63,492,249.85
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,234,807,792.89	2,392,663,131.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,252,311,257.44	2,422,405,564.98
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	3,550,120.97	5,903,740.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,548,259.40	3,943,923.56
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,064,085.90	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,162,466.27	9,847,664.34
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,162,466.27	9,847,664.34
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	111,595,600.00	111,595,600.00
2.3.2	Хувийн өмч		
2.3.3	Хувьцаат өр төлбөр		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		

2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,349,166,957.59	1,349,166,957.59
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,064,668,533.00	1,384,909,613.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(284,282,299.42)	(433,114,269.95)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,241,148,791.17	2,412,557,900.64
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2,252,311,257.44	2,422,405,564.98

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	69,762,577.40	290,643,266.70
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	69,762,577.40	290,643,266.70
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	113,046,000.00	186,395,200.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	371,780,198.04	625,870,437.23
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(188,971,620.64)	(148,831,970.53)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(188,971,620.64)	(148,831,970.53)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(188,971,620.64)	(148,831,970.53)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(188,971,620.64)	(148,831,970.53)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	972,145,473.00	(95,310,678.78)	2,337,597,351.81
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	972,145,473.00	(95,310,678.78)	2,337,597,351.81
4	Өмчид гарсан өөрчлөлт			92,523,060.00	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(188,971,620.64)	(188,971,620.64)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,064,668,533.00	(284,282,299.42)	2,241,148,791.17
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,064,668,533.00	(284,282,299.42)	2,241,148,791.17
13	Өмчид гарсан өөрчлөлт			320,241,080.00		
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(148,831,970.53)	(148,831,970.53)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,384,909,613.00	(433,114,269.95)	2,412,557,900.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	192,016,226.40	467,249,715.50
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	78,970,226.40	280,854,515.50
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	113,046,000.00	186,395,200.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	192,911,862.26	451,621,697.38

1.2.1	Ажилагсад төлсөн	96,434,768.05	195,780,992.44
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	14,602,109.07	29,607,544.26
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	28,907,659.80	14,120,425.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	26,574,802.34	119,085,170.68
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,869,523.00	20,056,820.97
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	246,500.00	751,175.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	276,500.00	350,370.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	71,869,199.03
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(895,635.86)	15,628,018.12
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	14,248,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	14,248,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(14,248,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(895,635.86)	1,380,018.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,048,677.41	153,041.55
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	153,041.55	1,533,059.67

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
2	Нийт орлого	182,808,600.00	467,249,715.50	477,038,466.70	9,788,751.20	102.09
	Үүнээс: Цэвэр борлуулалт	182,808,600.00	280,854,515.50	290,643,266.70	9,788,751.20	103.49
	Бусад орлого	0.00	186,395,200.00	186,395,200.00	0.00	0.00
3	Нийт зардал	0.00	0.00	0.00	0.00	0.00
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00	0.00	0.00	0.00
	б) Ерөнхий удирдлагын зардал	371,780,200.00	465,819,697.38	625,870,437.23	160,050,739.85	134.36
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Цэвэр ашиг, алдагдал	(188,971,600.00)	1,430,018.12	(148,831,970.53)	(150,261,988.65)	0.00

3. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитын явцад дараах алдаануудыг залруулсан. Үүнд:

- Орлого үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланг 1,517.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээг 50.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүнг 40,139.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,

Санхүүгийн тайланд нийт 41,707.0 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

Аудитаар нийт 45,578.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1,780.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 43,798.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1.Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой асуудал.

Илрүүлэлт. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр гүйцэтгэх удирдлагад 1,208.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан

тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн урамшууллын нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох .

3.2.Төлбөрийн акт нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны Улсын ахлах байцаагчийн 2023 оны 02 сарын 27 өдрийн 25-06-02-23/11 тоот шатахууны үнэ төлүүлэх тухай 218.9 мянган төгрөгийн, 25-06-02-23/13 тоот материалын үнийг төлүүлэх тухай 353.3 мянган төгрөгийн төлбөрийн актуудыг хариуцагч нараар төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5-д "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх төлбөрийн актуудыг хариуцагч нараар нөхөн төлүүлэх акт тогоох.

3.3 Албан шаардлага

1.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нүүрс тээврийн ажлын хөлсийг олгохдоо тодорхой тогтоосон тариф үнэлгээгүй, анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулаагүй ажлын хөлс, нүүрс тээврийн зардалд 38,578.5 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тээврийн ажлын хөлс олгох үнэ, тариф үнэлгээг шинэчлэн тогтоож шийдвэрлэх албан шаардлага өгөх.

2.Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд гүйцэтгэх удирдлага хөрөнгийн тооллого хийх тушаал шийдвэр гаргаагүй, хагас бүтэн жилийн тооллого хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна", 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах", 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72.4-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн дотоодын тооллогыг тогтоосон хугацаанд явуулах, баталгаажуулах тайлан мэдээг бэлтгэн ажиллах албан шаардлага өгөх.

3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажил гүйцэтгэх гэрээг баталгаажуулаагүй, гүйцэтгэлийн тайлан, хүлээн авсан хүлээлгэн өгсөн актууд үйлдээгүй, гүйцэтгэгч талаас нотлох анхан шатны баримтгүйгээр 5,220.0 мянган төгрөгийн ажлын хөлс шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй ажиллах албан шаардлага өгөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн	1	1,517.3			1	1,517.3	1	1,517.3				
Нийт цэвэр мөнгөн гүйлгээг дутуу илэрхийлсэн	1	50.0			1	50.0	1	50.0				
Өмнөх үеийн үр дүнг дутуу илэрхийлсэн	1	40,139.7			1	40,139.7	1	40,139.7				
Дүн	3	41,706.9	0	0	3	41,706.9	3	41,706.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажлын хөлс, нүүрс тээврийн зардлыг олгосон.	1	38,578.5			1	38,578.5						
Тайлант онд тооллого хийгээгүй байна.	1	-			1	-						
Нотлох дэмжих баримтгүй шилжүүлэг хийсэн байна.	1	5,220.0			1	5,220.0						
Төлбөрийн актуудыг хариуцагч нараар төлүүлээгүй байна.	1	572.2	1	572.2								
Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр гүйцэтгэх удирдлагад үр дүнгийн урамшуулал олгосон.	1	1,208.2	1	1,208.2								
Дүн	5	45,578.9	1	1,780.4	4	43,798.5	0	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухайн хуулийн 6.4.8 -д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 7,103.4 мянган төгрөгийн 2 шийдвэр мэдээлээгүй байна.	1	205,355.2					1	205,355.2
Дүн	1	205,355.2					1	205,355.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Газрын даргын 2023 оны тушаалын хавсралтууд, ур чадвар болон нэмэгдэл олгох хувь хэмжээг гараар засаж нэмэгдлүүд олгосон, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох тушаалуудын хууль, эрх зүйн үндэслэл хангалтгүй, мөн нэмэгдэл цалин үр дүнгийн урамшуулал олгох шалгуур үзүүлэлтийн журам боловсруулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.	1	-			1	-		
Тухайн байгууллагын нүүрсний худалдан авалтыг гэрээ, гүйцэтгэлтэй тулгахад гэрээ хийгээгүй, баталгаажуулаагүй, гэрээний үнийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоогоогүй худалдан авалт хийсэн байна.	1	72,088.5			1	72,088.5		
Дүн	2	72,088.5	-	-	2	72,088.5	-	-
Нийт дүн	3	277,443.7	0.0	0.0	2	72,088.5	1	205,355.2